

БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ ЯВЦАД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтнууд болон эцэг эх,
асран хамгаалагчдын зөвлөлийн гишүүдэд зориулсан гарын авлага

Улаанбаатар хот
2025 он

© Хүүхдийг Ивээх Сан, 2025 он

“Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтийн үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь” гарын авлагын тус хэвлэлд орсон бүх текст, зураг, бүдүүвч нь Хүүхдийг Ивээх Сангийн оюуны өмчид хамаарах ба Хүүхдийг Ивээх Санд бичгээр мэдэгдэн зөвшөөрөл авч цаашид боловсруулахад ашиглана уу. Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Хөтөлбөрийн газраас болон цахим хэлбэрээр www.savethechildren.mn хуудаснаас авах боломжтой.

Зохиогч: Зөвлөх Сэргэлэнгийн Баттулга
Батхуягийн Батжаргал

Техникийн редактор: Жамцсүрэнгийн Батцэцэг
Чимэдийн Мөнгөнтуяа

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол Улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: mongolia.secretary@savethechildren.org

“СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” төслийн хүрээнд Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрөөс боловсруулав.

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг, мэргэжлийн, бие даасан, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлын эсрэг, Хүмүүнлэгийн тусламж, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

АГУУЛГА

Удиртгал	4
Хүүхэд хамгааллын тухай	6
Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал ба хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив	11
Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал ба санхүүжилт . .	19
Төсөв, санхүүжилт	22
Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтийн үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломж	26
Дүгнэлт, зөвлөмж.	34
Хавсралт	36
Ном зүй.	40

УДИРТГАЛ

Монгол Улсын “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр батлагдаж, 2024 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд тус хуулиар хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахыг зорьсон.

Үндэсний Аудитын Газраас 2024 онд хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, хүүхэд хамгааллын асуудлыг хамарсан, цогц уялдаа холбоо бүхий төрийн бодлого, үр дүнтэй тогтолцоог төлөвшүүлэх, сайжруулах шаардлагатай байгааг онцолжээ.

Мөн санхүүгийн нөөцийг судалгаа, статистик тоо мэдээлэлд үндэслэн төлөвлөж чадахгүй байна гэж дүгнээд хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг.

Хүүхэд хамгааллын асуудал бүх салбар тэр дундаа боловсролын салбар, сургуулийн орчинд чухлаар яригддаг сэдэв юм. Боловсролын салбар, Ерөнхий боловсролын сургуулийн төсөвт хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хүүхэд хамгааллын зардал төсөвлөгдсөн байдаг бөгөөд уг санхүүжилтийг төлөвлөх, зарцуулах зааврыг Боловсролын

сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/279 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Зааврын дагуу сургуулийн хүүхэд хамгааллын ажлыг сургуулийн хүүхэд хамгааллын баг удирдан сургуулийн удирдлага, багш ажилтан, албан хаагч, эцэг эхийн зөвлөл, мэргэшсэн байгууллага, мэргэжилтэн, суралцагч, сургагч багшийн оролцоотой хамтран зохион байгуулдаг.

Энэхүү товч гарын авлагыг Хүүхдийг Ивээх Сангаас 2023-2025 онуудад хэрэгжүүлсэн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд сургуулийн орчинд зохион байгуулагддаг хүүхэд хамгааллын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг үнэлэхэд олон нийт буюу эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог хангах нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслийг бий болгох зорилгоор боловсрууллаа.

Гарын авлагад тусгасан 2 маягт, аргачлалыг ашиглан сургуулиуд хүүхэд хамгааллын арга хэмжээгээ эцэг эх, асран хамгаалагчдын оролцоотойгоор төлөвлөх боломжтой болох төдийгүй хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнтэй байдлыг тайлагнаж, үнэлүүлэх замаар хүүхэд хамгааллын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд олон нийтийн оролцоог хангаж, нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэхэд ахиц гарна гэдэгт итгэж байна.

Гарын авлагыг боловсруулах ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн баг болон гарын авлагын эхний боловсруулалтыг хянаж, үнэтэй санал, зөвлөмж өгсөн Хүүхэд хамгааллын арга зүйн төвийн ахлагч Ч.Мөнгөнтуяад, төслийн зохицуулагч Ж.Батцэцэг нарт гүн талархал илэрхийлье.

Зөвлөх С.Баттулга
Зөвлөх Б.Батжаргал
2025 оны 12 дугаар сар

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ



2024 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2024 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Тус хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино.

Хуульд зааснаар “хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг хэлэх бөгөөд дараах хэлбэртэй байдаг. Үүнд:



Шуурхай тусламжийн үйлчилгээ гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл хүлээн авсан, өөрөө илрүүлсэн сум, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн алба хаагч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон бол хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлж, аюулыг

зайлуулах, аюул учруулах нөхцөл байдлыг арилгах яаралтай арга хэмжээг хэлж байгаа юм. Шаардлагатай гэж үзвэл хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр аюултай нөхцөл байдал арилах хүртэл аюулгүй газар түр байрлуулж болдог. Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн, хүүхдийн зан байдал нь өөрийн, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулахаар нөхцөл байдалд байгааг “хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон” гэж үзнэ. Өөрөөр хэлбэл хүүхдийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулахаар нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хойшлуулшгүй арга хэмжээ авч байгааг шуурхай тусламжийн үйлчилгээ гэж ойлгох юм. Шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, эмнэлгийн яаралтай тусламж, сэтгэл зүйн болон хууль зүйн анхан шатны зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээнд нэн даруй холбон зуучлах бөгөөд шаардлагатай тохиолдолд хүүхдийг хамгаалах аюулгүйн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ нь хүүхэд хамгааллын үйлчилгээний чухал хэлбэр бөгөөд хүүхдийг асрах, өсгөн хүмүүжүүлэх талаар зөвлөгөө өгөх, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх; сэтгэл зүйн цочрол, хямрал, гэмтлээ даван туулахад нь туслах сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх; хүүхдийн эсрэг хүчирхийллээс үүдэлтэй хүүхдийн зан авирын өөрчлөлтөд чиглэсэн нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх; хүүхдийг суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх зорилгоор хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон сургалт, үйл ажиллагаанд хамруулах, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх; хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх; сургууль завсардсан хүүхдийн чадвар, хөгжлийн онцлог, сонирхлыг судалж, зохих боловсролын байгууллагад холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх; амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор гэр бүлд тусламж, дэмжлэг үзүүлэх, ажлын байранд холбон зуучлах гэх зэрэг олон төрлийн зөвлөгөө өгөх, холбон зуучлах, дэмжих үйлчилгээ байдаг.

Өөр нэг чухал үйлчилгээ бол **урьдчилан сэргийлэх үйлчилгээ** юм. Тус үйлчилгээ нь зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ; олон талт, хамтарсан арга хэмжээ гэсэн 2 үндсэн хэлбэртэй бөгөөд хүүхдийг аюултай нөхцөл байдал орохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бүх төрлийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хамруулан ойлгож болно.

Хүүхэд хамгааллын хуулийн 23 дугаар зүйлд “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал”-ын талаар тусгайлан зааж, бүх шатны боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм хийдийн шашны сургууль хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байхаар хуульчилсан. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд голлон төвлөрсөн байдаг. Үүнд:



хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах;



гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулах;



хүүхдийг хорт зуршил, согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах;



хичээлийн жилийн турш хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, зөвлөгөө өгөх, хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх, тандан судлах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;



хүүхэд хоорондын болон хүүхэд, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хоорондын харилцаанаас үүссэн зөрчил, хүүхдэд тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэх зэрэг болно.

Монгол Улсын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрддэг салбар дундын, нийлмэл тогтолцоо юм. Үүнд хамрагдахгүй төрийн байгууллага, хуулийн этгээд байхгүй. Тодруулбал, төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүүхэд хамгааллыг дэмжих, хэрэгжүүлэх үүрэгтэй бол ажил олгогч, хуулийн этгээд дотооддоо хэрэгжүүлэх байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахаар хуульд заасан байдаг. “Хүүхэд хамгааллын бодлого” гэж хүүхдийг эрсдэлт нөхцөлд орох, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх зорилго, зорилт, ажилтны мөрдөх ёс зүйн хэмжээг тодорхойлсон тухайн байгууллага, хуулийн этгээдээс баталсан баримт бичгийг ойлгоно.



Шигтгээ:

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Бадамцэцэгийн ярилцлагаас

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зорилготой төрийн анхан шатны нэгж сум, хороо, багийн 803 хамтарсан баг үндэсний хэмжээнд ажиллаж байна. Эл хамтарсан багт энэ жилээс Хүүхэд хамгааллын хуулийн шинэчлэлтээр шинээр хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нэмэгдэж, нарийн бичгээр ажиллах боллоо.

Тэд, хариуцсан нутаг дэвсгэртээ эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлэх, мөн Хүүхдийн тусламжийн утас 108, цагдаагийн 102 дуудлагаар бүртгэгдэж, шилжиж ирсэн кейс бүрд нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх кэйс менежментийг зохицуулдаг.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын харьяа анхан шатанд ажилладаг ажилтантай болсноор хамтарсан багийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ идэвхжиж, кейсийн шийдвэрлэлтийн дундаж үзүүлэлт 74.4 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 10-аад хувиар дээшилж байна. Урьд нь хүүхэд, гэр бүлийн салбарт харьяалагдах ийм мэргэжилтэн байгаагүй.

Эх сурвалж: gogo.mn

Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалтын хувьд Засгийн газар, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багаас бүрдэнэ. Хуульд заасны дагуу Засгийн газар хүүхэд хамгааллыг тогтвортой санхүүжилтээр хангах чиг үүрэгтэй бол хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар (ХГБХХЕГ) хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх, зарцуулалтад хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг. Нутгийн өөрөө удирдах байгууллага буюу аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хүүхэд хамгааллын санхүүжилт, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгаж батлах чиг үүрэгтэй.

Хуулийн 6 дугаар бүлэгт хүүхэд хамгааллын санхүүжилт ба хяналтыг авч үзсэн байдаг. Хүүхэд хамгааллын санхүүжилтийг хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, хэлбэр тус бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ. Хүүхэд хамгааллын санхүүжилтийг төлөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейсийн тоо, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн дараа онд олгох санхүүжилтийг тогтоодог. Хүүхэд хамгаалалд тусгасан төсвийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн байгууллага, хууль зүйн хороо, хамтарсан баг болон гэрээгээр хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаанд зарцуулах бөгөөд хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын нормативыг Засгийн газар баталдаг юм.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ БА ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ДУНДАЖ ЗАРДЛЫН НОРМАТИВ



Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52.8-д заасныг үндэслэн 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 236 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал”, “Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив”-ыг тус тус батлан мөрдөж эхэлсэн.

Тус аргачлалд зааснаар санхүүжилт олгоход үйлчилгээний хэлбэрээс хамаарч дараах чиглүүлэгчийг ашиглана:



Тухайн нутаг дэвсгэр дэх нийт болон зорилтот өрх, хүн амын тоо



Мэдээллийн нэгдсэн сан болон кейсийн тоо



Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо



Үзүүлсэн үйлчилгээний гүйцэтгэл

Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан төрийн байгууллага дээрх чиглүүлэгч ашиглан тооцсон санхүүжилтийг хамтарсан баг, хүүхэд хамгааллын үйлчилгээгээр мэргэшсэн хүн, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд, асралт гэр бүлд үйлчилгээ үзүүлэх гэрээг үндэслэн олгодог. Үйлчилгээ үзүүлэгч нь кейс бүрд үйлчилгээ үзүүлэхэд гарах зардал болон шаардлагатай тохиолдолд төлбөртэй нэмэлт үйлчилгээ авахад гарах зардлыг уг аргачлалын дагуу тооцож, санхүүжилтийн хүсэлт буюу зардлын нэхэмжлэхийг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад гаргах замаар санхүүжилтээ авна гэсэн үг.



Шигтгээ:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч Ж.Азжаргалын ярилцлагаас

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52 дугаар зүйлд санхүүжилтийн эх үүсвэрийг улсын, орон нутгийн төсөв, үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр, дотоод гадаадын хуулийн этгээд болон

олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив тусламж гэсэн дөрвөн эх үүсвэртэй байхаар заасан. Мөн Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөж, хэрэгжүүлэх шинэ зохицуулалттай болсон. Төрийн бүх байгууллага хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэх, дэмжих болон хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийг хуулийн этгээд бүр сурталчлах үүрэгтэй. Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, зардлыг улсын төсөвт тусгах арга хэмжээ авч ажиллах юм.

Түүнчлэн нутгийн өөрөө удирдах байгууллага хүүхэд хамгааллын санхүүжилт, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт тусгаж батлах зохицуулалттай болсон.

Эх сурвалж: “Зууны мэдээ” сонин, 2025 оны аравдугаар сарын 23. Пүрэв гараг. № 200 (7697).

Шуурхай тусламжийн үйлчилгээний зардал

Шуурхай тусламжийн үйлчилгээний зардалд дараах зардал хамаарна:



Анхан шатны тусламжийн зардал

- анхан шатны багцын зардал (эм, ариун цэврийн хэрэгсэл, зөөлөн эдлэл, шаардлагатай тохиолдолд хувцас)
- шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд гарсан бичиг хэрэг, харилцаа холбоо, шатахууны зардал



Шаардлагатай бусад

- тухайн кейсийн онцлог, хүчирхийллийн хэлбэрээс шалтгаалан шаардагдах бусад зардал

Анхан шатны тусламжийн зардлыг хамтарсан багийн ирүүлсэн санхүүжилтийн хүсэлтэд үндэслэн сар бүр багцаар олгодог бол

нөхцөл байдлын үнэлгээ хийж кейс нээх, кейс менежментийн төлөвлөгөө боловсруулахад оролцсон хамтарсан багийн гишүүн, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд олгох урамшууллыг сар бүр нормативын дагуу тооцож, улирал бүр олгохоор аргачлалд туссан.

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардалд дараах зардал хамаарна:



холбон зуучлах, бичиг баримт баталгаажуулах зардал



гэр бүлээс тусдаа орчинд үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн хоолны зардал



кейс менежментийн төлөвлөгөөнд заасан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8.2-т заасан үйлчилгээний зардал



сэтгэл зүйн үйлчилгээ, хууль зүйн үйлчилгээ, эрүүл мэндийн төлбөртэй үйлчилгээ, гамшиг, онцгой нөхцөл байдлын үед үзүүлэх үйлчилгээ, ялгаатай хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээнд хамрагдсан хүүхдэд олгох хөгжлийн хэрэглэгдэхүүний зардал



үйлчилгээний нэмэлт багцын зардал (хүүхдийн нас, хүйс, биеийн онцлог, хүчирхийллийн хэлбэрээс шалтгаалсан хүнс, эм, ариун цэврийн хэрэгсэл, шаардлагатай тохиолдолд хувцас, түлээ түлшний зардал)

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд баримтлах дундаж үзүүлэлтийг аргачлалд дараах байдлаар тогтоосон байдаг бөгөөд тухайн төсвийн жилд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний тохиолдлын нийт дундаж нь доор дурдсан үйлчилгээний төрөл болон хүчирхийллийн хэлбэр тус бүрээс ихгүй байна:

- бие махбодын хүчирхийллийн хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний дундаж давтамж 8, бэлгийн хүчирхийллийн болон сэтгэл санааны хүчирхийллийн хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний дундаж давтамж 18, үл хайхрах хүчирхийллийн хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний дундаж 4;
- гэр бүлээс тусдаа орчинд үйлчилгээ авч байгаа тохиолдолд бие махбодын хүчирхийллийн хохирогч 49 ор хоног, бэлгийн хүчирхийллийн хохирогч 182 ор хоног, сэтгэл санааны хүчирхийллийн хохирогч 49 ор хоног, үл хайхрах хэлбэрийн хүчирхийллийн хохирогч 14 ор хоног.

Кейс менежментийн үйлчилгээний төлөвлөгөөнд заасан тохиолдолд дараах үйлчилгээг гүйцэтгэлээр нь тооцон олгож болдог ба эрх бүхий этгээдээс баталсан норматив, тарифыг баримтлан санхүүжүүлнэ:

- сэтгэл зүйн төлбөртэй тусламж, үйлчилгээ;
- хууль зүйн үйлчилгээ;
- зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн төлбөртэй тусламж үйлчилгээ;
- ялгаатай хэрэгцээтэй¹ хүүхдэд шаардагдах үйлчилгээ.

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн хамтарсан багийн гишүүн болон холбогдох албан тушаалтанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тарифыг баримтлан дотоод албан томилолтын зардал олгож болно.

Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардал

Урьдчилан сэргийлэх үйлчилгээг хүүхэд хамгааллын асуудал хариуцсан төрийн байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хамтарсан баг, мэргэшсэн хүн, хуулийн этгээдээр дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд зардлын бүрэлдэхүүнд нь сургалтын хэрэглэгдэхүүний зардал, сургагч багшийн цагийн хөлс,

1 Боловсролын ерөнхий хуулийн 3.1.24-т заасны дагуу “ялгаатай хэрэгцээ” гэдэг нь хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендер, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг ойлгоно.

нөлөөллийн ажлын зардал, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн хөгжлийн хэрэглэгдэхүүний зардал, сургалт, нөлөөллийн ажилтай холбоотой бусад зардал багтах бөгөөд дараах байдлаар тооцож санхүүжүүлнэ:

- хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах зорилго бүхий сургалт, нөлөөллийн ажлын зардлыг орон нутгийн хүүхдийн тоонд үндэслэн;
- олон нийтэд чиглэсэн хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага, дадлыг олгох сургалт, нөлөөллийн ажлын зардлыг тухайн орон нутгийн хүн амын тоонд үндэслэн;
- эцэг, эх, гэр бүлд чиглэсэн хүний эрх, жендер, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ёс суртахуунтай иргэн төлөвшүүлэх арга, аргачлал, амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжүүлэх арга барил, явуулын үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий сургалт, нөлөөллийн ажлын зардлыг тухайн орон нутгийн өрхийн тоонд үндэслэн;
- хүний нөөцийг чадавхжуулах, салбар дундын зохицуулалтыг хангах зорилго бүхий сургалт, нөлөөллийн ажлын зардлыг хамтарсан багийн гишүүн, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүн, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч, шинжээч, сургалтад оролцогчдын тоонд үндэслэн;
- эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохирсон сургалт, нөлөөллийн ажлын зардлыг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо, үйлчилгээний төлөвлөгөөнд үндэслэн;
- урьдчилан сэргийлэх үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлсэн тохиолдолд бичиг хэрэг, тээвэр шатахуун болон албан томилолтын зардлыг холбогдох нормативын дагуу.

Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлаас тэмцээн уралдаан, урлагийн арга хэмжээ, кино, жүжиг зэрэг соёлын арга хэмжээг санхүүжүүлдэггүй гэдгийг анхаарах хэрэгтэй.



Шигтгээ:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мягмарсүрэнгийн ярилцлагаас

Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хөтөлбөрийн төсөв 2023 онд 7.9, 2024 онд 13.7 тэрбум төгрөг байсан. Харин энэ онд 20.6 тэрбум төгрөг болж өссөн. Зардлын аргачлал, норматив, тухайн нутаг дэвсгэр дэх нийт болон зорилтот өрх, хүн амын тоо, мэдээллийн нэгдсэн сан болон кейсийн тоо, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, үзүүлсэн үйлчилгээний гүйцэтгэл зэрэг нь төсвийг нэмэхэд нөлөөлсөн. Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний зардалд 2025 онд анх 20.6 тэрбум төгрөг батлагдсан ч 2025 оны төсвийн тодотголоор 20.3 тэрбум төгрөг болгож бууруулсан. 2025 оны гуравдугаар улирал буюу есдүгээр сарын 30-ны байдлаар Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний хөтөлбөрийн батлагдсан төсөв 16.1 тэрбум төгрөгөөс 9.2 тэрбум төгрөг буюу 57.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Засгийн газрын 236 дугаар тогтоолоор батлагдсан хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлалд бүх үйлчилгээг нарийвчлан тусгасан. Анхан шатны тусламжийн багцад эм, ариун цэврийн хэрэглэл, зөөлөн эдлэл, шаардлагатай тохиолдолд хувцас гэх мэтээр тодорхой зааж өгсөн. Мөн хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх зураглал баталсан. Үүгээр ямар тохиолдолд зардал олгохгүйг хүртэл нарийвчилж заасан. Жишээ нь, Хүүхдийн тусламжийн утас 108-ын дуудлага аваад, зөвлөгөө өгч хаасан тохиолдолд санхүүжилт олгохгүй. Цагдаа аюулгүй байдлын зэргийн үнэлгээ хийж, “бага эрсдэлтэй” гэж үзвэл мөн санхүүжилт олгохгүй. Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн хэрнээ кэйс нээгээгүй тохиолдолд санхүүжилт өгөхгүй байх нь. Харин нөхцөл байдлыг нь үнэлж, кэйс нээж, төлөвлөгөө гаргаж ажилласан тохиолдолд санхүүжилт олгоно. Тухайлбал, бичиг хэргийн зардал 5000, харилцаа холбооны зардал 4000 төгрөг гэх мэтээр тооцдог. Түүнчлэн эрүүл мэндийн төлбөртэй тусламж, сэтгэл засал, сэтгэл зүйн, хууль зүйн гэх мэт үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай зардлыг тусгаж, салбар дундын баримталж байгаа норм, нормативаар тооцогдохоор байгаа.

Эх сурвалж: *ikon.mn*

Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив

№	Зардлын төрөл	Нэгж	Давтамж	Норматив (төгрөгөөр)
1.	Бичиг хэргийн зардал	Хүүхдийн тоо	Тохиолдол бүрд	5,000
2.	Харилцаа холбоо (холбон зуучлах)-ны зардал			4,000
3.	Хүүхэд хамгааллын үйлчилгээний анхан шатны багц			20,000
4.	Бичиг баримт баталгаажуулах зардал			6,500
5.	Нөхцөл байдлын үнэлгээ (НБҮ) хийсэн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд олгох урамшуулал	НБҮ-ний тоо		63,000
6.	Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэмэлт багц	Хүүхдийн тоо	Шаардлагатай тохиолдолд тухайн арга хэмжээнд	40,000
7.	Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдэд шаардлагатай хүүхдийн хөгжлийн хэрэглэгдэхүүн	Хүүхдийн тоо		50,000
8.	Урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэгч сургагч багшийн цагийн хөлс	Багшийн тоо		70,000
9.	Сургалтын хэрэглэгдэхүүн	Хүний тоо		5,000
10.	Сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны бусад зардал	Хүний тоо		5,500

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 236 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ БА САНХҮҮЖИЛТ



Хүүхэд хамгаалал нь Монгол Улсын боловсролын салбарын бодлогын салшгүй хэсэг бөгөөд хүүхэд бүрийн аюулгүй, хүчирхийллээс ангид орчинд өсөж, сурч, хөгжих баталгааг хангах зорилготой.

Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн А/453 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-аар зохицуулдаг. Энэхүү хүүхэд хамгааллын үйлчилгээнд

- шуурхай тусламжийн
- хамгаалах нөхөн сэргээх
- хүчирхийлэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа багтана.

Журамд зааснаар ерөнхий боловсролын сургууль бүр Хүүхэд хамгааллын багтай байна. Хүүхэд хамгааллын багийг сургуулийн захирал ахлах ба сургуулийн нийгмийн ажилтан, сургалтын менежер, эмч, сэтгэл зүйч, багш нарын төлөөллөөс бүрдэн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

№	Бүрэлдэхүүн	Чиг үүрэг
1	Захирал	Сургууль, дотуур байрны орчинд хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах, хянах
2	Сургуулийн нийгмийн ажилтан	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх мэргэжлийн үйлчилгээг хүргэх ажлыг чиглүүлж, зохион байгуулах

3	Сургалтын менежер	Хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээг тасралтгүй хүргэх ажлыг зохион байгуулж, суралцагчийг сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, хяналт тавих Хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй хэрэгцээ үүссэн, гачигдал тохиолдсон болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас танхимаар суралцах боломжгүй болсон нь нотлогдсон тохиолдолд хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй зохион байгуулах зорилгоор ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулж, сургалтад хамруулах, холбогдох зохицуулалтыг танхимын сургалтад хэвийн хамрагдах хүртэл хугацаанд хийж, сургалтын баримт бичиг баталгаажуулах ажлыг нийгмийн ажилтан, анги удирдсан багш, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран зохион байгуулах
4	Сургуулийн эмч	Хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй хүүхдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад холбон зуучлах
5	Сургуулийн сэтгэл зүйч	Хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх
6	Анги удирдсан багш	Хүүхдийн хичээл хоцролт, таслалт, сургууль завсардалт, зан үйлийн өөрчлөлтийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг тандан судалж, хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй хүүхдийг илрүүлэх, мэдээлэх, улмаар хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран зохион байгуулах
7	Сургуулийн дотуур байрны багш	Дотуур байрны орчинд хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хүүхдийн эсрэг хүчирхийллийн сэжиг таамаг, хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр сургуулийн хүүхэд хамгааллын багийн гишүүдтэй хамтран ажиллах

Ерөнхий боловсролын сургуулийн захирал сургуулийн багш, ажилтныг шинээр ажилд томилоход хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчил, гэмт хэрэгт холбогдсон эсэхийг холбогдох бичиг баримтад үндэслэн нягтлан шалгахын зэрэгцээ энэхүү асуудлыг багш, ажилтан сонгон шалгаруулах журам, хөдөлмөрийн дотоод журамд тусгана.

Түүнчлэн Хүүхэд хамгааллын багийн ахлагч багийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалт, арга хэмжээг суралцагч, сургууль, орон нутгийн онцлогт тохируулан тогтмол зохион байгуулахаар заасан.

Сургууль болон дотуур байрны орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, орчны эрсдэлийн үнэлгээг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах бөгөөд эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр мөн заажээ.

Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх үйл ажиллагааны төлөвлөгөөг “Сургуулийн хүүхэд хамгааллын баг” хичээлийн жил бүр боловсруулж, сургуулийн зөвлөлөөр батлуулан, хэрэгжилтийг хичээлийн жил бүрийн эцэст аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтэст тайлагнадаг.

Сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээ, үйл ажиллагаа нь дараах хэлбэр, төрөлтэй байна. Үүнд:

- ганцаарчилсан, бүлгийн зөвлөгөө,
- сэтгэл засал,
- сургалт,
- гэрээр айлчлах,
- уулзалт,
- сурталчилгаа,
- арга хэмжээ,
- хөтөлбөр,
- нөлөөллийн ажил

Боловсролын газар, хэлтэс дээрх тайлантай танилцаж, дараагийн хичээлийн жил эхлэхээс өмнө сургууль бүрд холбогдох санал, зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавихаас гадна энэхүү журмын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээг хоёр жилд нэг удаа хийхээр заажээ. Эдгээрт шаардагдах төсвийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, төсвийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих үүргийг мөн боловсролын газар, хэлтэс хүлээнэ.

ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ



Боловсролын Ерөнхий хуулийн 38.1.2-т хувьсах зардлын бүрэлдэхүүнд сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын зардал багтахар заасан.

Сургуулийн хүүхэд хамгааллын зардлын нийт хэмжээ нь Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан хувь хэмжээгээр тогтоогдоно. Уг тогтоолын хоёрдугаар хавсралтад зааснаар ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын зардал нь нийслэлийн хувьд нийт хувьсах зардлын 0.268%, аймгийн төвийн хувьд нийт хувьсах зардлын 0,248% бол сумын сургуулийн хувьд нийт хувьсах зардлын 0.218% байна. Нөхөн хангалтын хувьсах зардлыг оруулаагүй нийт хувьсах зардлын дүн 1,397-2,125 мянган төгрөг байдаг тул нэг суралцагчид ногдох хүүхэд хамгааллын зардал дунджаар 3,045-4,632 төгрөг байдаг гэсэн үг юм.

Энэхүү зардлыг сургуулийн түвшинд төлөвлөх, хуваарилах зааврыг Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/279 тоот тушаалаар баталсан бөгөөд дараах байдлаар төсөвлөн зарцуулахаар заажээ.

Сургуулийн хүүхэд хамгааллын зардал дараах гурван үндсэн бүрэлдэхүүнтэй байна.

1. Нийт суралцагчийг хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршил, согтуурах, мансуурах, донтох байдал болон цахим орчин дахь болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх, өртсөн суралцагчийг дахин өртөхөөс сэргийлэх сургалт, үйл ажиллагааны зардал – сургуулийн хүүхэд хамгааллын нийт зардлын 50 хүртэлх хувийг төсөвлөн зарцуулна.
 - a. Эрсдэлд өртөх эрсдэлтэй болон өртсөн суралцагчийг дахин өртөхөөс сэргийлэх тодорхой бүлэгт чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө, үйл ажиллагааны зардал
 - b. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних, илрүүлэх, мэдээлэх тухай сургуулийн багш, ажилтнуудад зориулсан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлын зардал
 - c. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмшүүлэх талаар суралцагч, эцэг эх, сургуулийн үйл ажиллагаанд хамтран оролцогч талуудад зориулсан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлын зардал
 - d. Сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээг зохион байгуулах, хянах, үнэлэх, тайлагнахад шаардлагатай үйл ажиллагааны зардал
2. Сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн суралцагчид үзүүлэх хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн зардал – хүүхэд хамгааллын нийт зардлын 20 хүртэл хувийг төсөвлөн зарцуулна.
 - a. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй мэдээлэл, таамгийг хүлээн авах тусгай дугаар бүхий харилцаа холбооны хэрэгсэл, утасны холбогдох төлбөр
 - b. Хүчирхийллийн хохирогч суралцагчид үзүүлэх яаралтай, тусламж, үйлчилгээнд шаардлагатай техник хэрэгслийн зардал

- с. Хохирогч суралцагчийг хүүхэд хамгааллын болон холбогдох байгууллагын тусламж, үйлчилгээнд цаг алдалгүй хүргэх, холбон зуучлах тээвэр шатахууны зардал
3. Хүчирхийлэлд өртсөн суралцагчийг хамгаалах, нөхөн сэргээх, суралцах үйл явцыг дэмжихэд чиглэсэн хүүхэд хамгааллын хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал – сургуулийн хүүхэд хамгаалах нийт зардлын 30 хүртэл хувийг төсөвлөн зарцуулна.
- а. Хүчирхийллийн хохирогч, эрсдэлт нөхцөлд байгаа суралцагч, суралцагчдын бүлгийг нөхөн сэргээх, дэмжих, чадваржуулахад чиглэсэн, сургуулийн нийгмийн ажлын, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн үйлчилгээнд шаардлагатай хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, зөвлөгөө, сэтгэл заслын уулзалтын зардал
- б. Хүчирхийллийн хохирогч, эрсдэлт нөхцөлд байгаа суралцагчид сургуулийн хүүхэд хамгааллын баг үзүүлэх боломжгүй нарийн мэргэжлийн үйлчилгээ нэмэлтээр авах тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний үйлчилгээний төлбөр
- с. Хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй байгаа суралцагч бүртэй ажиллах, кейс менежментэд шаардлагатай харилцаа холбоо, гэрээр айлчлах тээвэр, оролцогч талуудын уулзалтад шаардагдах зардал

Сургуулийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын багийн гишүүд дээрх хувь хэмжээнд нийцүүлэн тухайн жилд шаардлагатай материал, хэрэглэгдэхүүн, үйлчилгээний жагсаалтыг гарган төсвийн шууд захирагчаар батлуулна.

БУСАД ТАЛЫН ОРОЛЦОО



Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журамд иргэний нийгэм, салбар, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхдийг аливаа хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдал, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар заасан байдаг. Тэр дундаа хүүхдийн суралцах, хөгжих болон сайн сайхан байдлыг нь дэмжиж, сайжруулахад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо тун чухал юм. Эцэг эхийн оролцооны суурь нь Америкийн сэтгэл судлаач Юрий Бронфенбреннерийн дэвшүүлсэн “хүний/хүүхдийн хөгжлийн үйл явц түүнийг хүрээлэн байгаа орчны харилцан хамаарлаас бүрэлддэг” хүний хөгжлийн экосистемийн онол² байдаг. Эцэг эх, гэр бүлийн оролцоо нэмэгдсэнээр хүүхдийн суралцахуй, сайн сайхан байдалд эергээр нөлөөлдөг. Тиймээс сургуулийн хамт олон эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо чухлыг ойлгон ухаарч, тэдэнд оролцох арга замыг зааж чиглүүлж өгөх нь тэдний оролцоог илүү утга учиртай болгодог байна.




Шигтгээ:

Ю.Бронфенбреннерын хүний хөгжлийн экосистемийн онол

Хүүхдэд энэ бүх орчин нөлөөлдөг гэдгийг анхаарч, хүүхдийн сайн сайхан байдал энэ бүх орчинд оролцож байгаа насанд хүрэгч бүрийн хамтын үүрэг бөгөөд хүүхдийн сайн сайханд нөлөө үзүүлж байгаа насанд хүрэгч бүр хүүхдийн хамгийн дээд ашиг сонирхлын төлөө байж, түүнийгээ биелүүлэхийг уг экосистемийн онол сануулж байдаг. Гэр бүл, тэр дундаа эцэг, эх хүүхдэд хамгийн ойр буюу ойрын хүрээлэлд байж хамгийн их нөлөөг үзүүлнэ.

2 Bronfenbrenner, U. 1979. The Ecology of Human Development. Cambridge, MA. Harvard University Press.



Эх сурвалж: Bronfenbrenner, U. 1979. *The Ecology of Human Development*. Cambridge, MA. Harvard University Press.

Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтийн үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломж

Ерөнхий боловсролын сургуулиудын нийтлэг туршлагаас үзэхэд хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлж дүгнэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог тэр бүрийд хангахгүй байгаа нь ажиглагдсан. Гэтэл уг үйл ажиллагааны нэг чухал оролцогч тал нь гарцаагүй эцэг эх, асран хамгаалагчид юм.

Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн хүрээнд Ховд аймагт хэрэгжсэн “Олон нийтийн оролцоотой сургууль” дэд төслийн хүрээнд аймгийн төвийн оролцогч талуудын хийсэн нөхцөл байдлын үнэлгээгээр ихэнх сургуулиуд засаглал, хөрөнгө, нөөцийн хуваарилалт, зарцуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах талаар иргэдэд мэдээлэл хүргэдэггүй, оролцоог хангадаггүй гэсэн дүгнэлт гарсан байдаг.



Шигтгээ:

Нийгмийн эгэх хариуцлага ба иргэдийн оролцоо

Нийгмийн эгэх хариуцлага

Нийгмийн эгэх хариуцлага нь “зохион байгуулалттай, чадваржсан иргэд төрийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, иргэдийн эрхийг хамгаалахын төлөө төрийн үйл ажиллагаанд бүтээлчээр оролцож, үр дүнг хянах үйл явц юм. Энэхүү явцад хяналт тавих, бүтээлч оролцоо, хамтын ажиллагаа тун чухал байдаг. Нийгмийн эгэх хариуцлага бэхэжсэний үр дүнд засаглал, төрийн бодлого, төрийн үйлчилгээ сайжирч, иргэд болон иргэний нийгмийн бүлгүүд хүчирхэгжинэ.

Иргэдийн оролцоо

Иргэд төрийн хэрэгт оролцохдоо бүтээлчээр, ажил хэрэгчээр оролцох нь туйлын чухал. Дэлхийн банкны Нийгмийн эгэх хариуцлагын дэлхийн түншлэлийн үзэл санаагаар бол БҮТЭЭЛЧ ХАМТЫН ОРОЛЦОО гэдэг нийгмийн эгэх хариуцлагын үйл ажиллагаа, тодорхой үйлдлээр дамжуулан төрийн зохих байгууллагуудтай солилцсон, хэлэлцсэн, мөн зохицуулсан ажил хэргийн үйл явц, эргэх холбоог хангах тухай ойлголт ажээ. Энэ бол өөрчлөлтийг эрчимжүүлэхийн тулд төрийн үйлчилгээ үзүүлэгчдийг татан оролцуулж нөлөөлөл хийх хандлага юм.

Эх сурвалж: Т.Түмэнцогтоо нар. 2017. Нийгмийн эгэх хариуцлагын үндсэн ойлголт. Улаанбаатар.

Энэ асуудлыг шийдэхийн тулд дэд төслийн хүрээнд олон нийтийн оролцоог сургуулийн үйл ажиллагаа, бодлого, дотоод журмын төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтад хангах хэрэгтэй. Дэд төслийн хүрээнд боловсруулж хэрэгжүүлсэн сургуулийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө нь олон талт оролцогчид буюу аймаг, сумын захиргаа, эцэг эхчүүд, олон нийт, бизнесийн байгууллага, төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж, тэдний дэмжлэгийг бий болгосон. Ингэснээр сургууль өөрийн хөрөнгө, нөөцөөр шийдвэрлэх боломжгүй олон тулгамдсан бодит асуудлууд дээр жишээ нь сургуулийн дотуур байрны засвар, сургууль дээр хүүхдийн чөлөөт цагаа өнгөрөөх байдалд хяналт тавих зэрэгт олон нийтийн анхаарлыг хандуулж бодит арга хэмжээ авч чаджээ. Хичээлийн жил эхлэхэд хүүхдүүдээ сургуульд “орхиод” явдаг малчин эцэг эхчүүд сургууль дээр дэд төсөл хэрэгжсэнээр өөрсдийн дотоод нөөц бололцоогоо дайчлан оролцсон нь дэд төслийн гол онцлог болсон юм.

Өөр нэг дурдаж болох жишээ бол Швейцарын хөгжлийн агентлаг, Дэлхийн банкны хамтарсан санхүүжилттэй “Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Өвөрхангай аймагт хэрэгжсэн “Олон нийтийн оролцоот сургууль” дэд төсөл байна. Уг санаачилгын хүрээнд тус аймгийн 10 сумын сургуулийн сурагчдын эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг хийжээ. Ингэхдээ тэдний эрхэлж буй ажил, амьжиргааны түвшинтэй уялдсан оролцооны хувилбаруудыг боловсруулан хэрэгжүүлэхийн зэрэгцээ тэдэнд эгэх хариуцлагыг бий болгосноор төр, иргэний хоорондох хамтын ажиллагаа, харилцаа нэмэгдэж байнга хамтран ажилладаг соёл төлөвшүүлэхийг анхаарлаа хандуулахыг зорьсон байна. Улмаар төслийн хүрээнд аавуудын оролцоог идэвхжүүлэхийн тулд сайн дурын багууд үүсгэж, “Морьтон аавуудын хөгжлийн төв” байгуулагдсан. Аавууд анги засварын ажил, эвдэрсэн сандал ширээ засахаас эхлүүлээд тодорхой ажил санаачлаад хийж эхэлсэн төдийгүй заалны ашиглалт, санхүүгийн зарцуулалт, хоол үйлдвэрлэл,

үйлчилгээ гэх зэрэг сургуулийн үйл ажиллагаанд тавих тэдний хяналт ч нэмэгдсэн байна. Ингэснээр аавууд багш нар, сургуулийн ажилтнуудтай хамтарч асуудлаа тодорхойлоод, шийдэх гарцыг хамтдаа эрэлхийлж, бүтээлчээр оролцох болжээ.³

Дээрх төслүүдийн амжилттай туршлагыг үндэслэн боловсролын салбар, тэр дундаа Ерөнхий боловсролын сургууль дээр хүүхэд хамгааллын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянахад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог бодитойгоор нэмэгдүүлэх замаар хүүхэд хамгааллын арга хэмжээг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Үүний тулд сургууль дээр зохион байгуулагдах хүүхэд хамгааллын арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтийг үнэлж, дүгнэхэд эцэг эх, асран хамгаалагчдын санал, бодлыг тусгах нийгмийн эгэх хариуцлагын механизмыг бий болгож, сургуулийн үндсэн үйл ажиллагаа болгон хэвшүүлэх хэрэгтэй. Арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад тэдний оролцоог хангаж, санал, бодлыг нь тусгахад дараах маягыг ашиглаж болох юм.

Сургууль дээр хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын арга хэмжээг төлөвлөх маягт (жишээ, загвар)

Хичээлийн жил:

Сургуулийн нэр:

Анги:

Анги удирдсан багшийн нэр:

Сурагчийн тоо:

Эцэг эхийн зөвлөлийн даргын нэр:

3 Т.Түмэнцогтоо нар. 2017. *Нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслүүд*. Улаанбаатар.

№	Арга хэмжээний нэр	Зорилтот бүлэг	Хэрэг-жүүлэх хугацаа	Шаардлагатай төсөв, төгрөг	Хариуцагч	Хамтрагч
1.						
2.						
3.						
4.						
5.						

Арга зүйн зөвлөмж: Дээрх маягтыг шинэ хичээлийн жилийн эхэнд анги тус бүрийн эцэг эх, асран хамгаалагчдын хурал дээр 5-6 гишүүн (эцэг эх, асран хамгаалагч гэсэн үг) бүхий багийн ажлаар хөндөж хэлэлцэх замаар бөглүүлж, улмаар үндэслэл бүхий хэрэгцээ шаардлагатай арга хэмжээг эрэмбэлж, олонхын дэмжлэг авсан эсэхээр ялган нэгтгэх боломжтой юм.

Маягтын тайлбар:

- **Арга хэмжээний нэр** хэсэгт эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага, дадлыг олгох сургалт, үйл ажиллагаа гэх мэтээр арга хэмжээний нэрийг бичнэ.
- **Зорилтот бүлэг** хэсэгт тухайн арга хэмжээг хэнд зориулан төлөвлөж байгааг бичнэ. Жишээлбэл эцэг эх, асран хамгаалагчид гэх мэт.
- **Хэрэгжүүлэх хугацаа** хэсэгт арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг бичнэ. Жишээлбэл 2026 оны 2 дугаар сард гэх мэт.
- **Шаардлагатай төсөв, төгрөг** хэсэгт сургалтын төлбөр, сургагч багшийн цагийн хөлс зэрэг арга хэмжээнд шаардагдах төсөв, санхүүжилтийн дүнг бичнэ.
- **Хариуцагч** хэсэгт сургуулийн зүгээс тухайн арга хэмжээг хариуцах үндсэн ажилтныг албан тушаалаар бичнэ. Жишээлбэл: сэтгэл зүйч гэх мэт.

- **Хамтрагч** хэсэгт бусад хамтрагч талыг бичнэ. Жишээлбэл: сургалт заах байгууллага, эцэх эхийн зөвлөл гэх мэт.

Энэ үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах анги удирдсан багш нарт сургуулийн хүүхэд хамгааллын багаас хичээлийн жилийн эхэнд уг гарын авлагын дагуу сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах замаар ойлголтыг нэмэгдүүлсэн байвал зохино. Анги удирдсан багш эцэг эх, асран хамгаалагчдын хурал дээр хэлэлцүүлгийн өмнө эцэг эх, асран хамгаалагчдад сургуулийн хүүхэд хамгааллын багаас боловсруулж өгсөн мэдлэг нэмэгдүүлэх мэдээллийн илтгэл (PPT)-ийг нэгдсэн байдлаар танилцуулна. Улмаар хэлэлцүүлгийг дараах байдлаар зохион байгуулна. Тухайлбал: эцэг эх, асран хамгаалагчдын баг тус бүрийн багаар ажиллах хугацааг 10-15 минут, баг тус бүрийн саналаа танилцуулах хугацааг тус бүр 5-10 минут, ангийн хэмжээнд нэгтгэн дүгнэх хугацааг 15-20 минутаас хэтрүүлэхгүй байхаар тус тус төлөвлөж, анги удирдсан багш хэлэлцүүлгийг чиглүүлнэ. Анги тус бүрийн саналыг анги удирдсан багш нар эцэг эх, асран хамгаалагчдын хурлаас хойш ажлын 5 хоногт багтаан нэгтгэж, сургуулийн нийгмийн ажилтанд хүлээлгэн өгнө. Нэгтгэсэн саналыг харгалзан сургуулийн хүүхэд хамгааллын багийн хурлаар сургуулийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээг тодорхойлж, сургуулийн эцэслэн батлагдсан хүүхэд хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөг бүх эцэг эх, асран хамгаалагчдад цаасаар буюу цахим байдлаар хүргүүлэхийг зөвлөж байна.

Тухайн хичээлийн жилийн төгсгөлд дээрх сургуулийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эцэг эх, асран хамгаалагчдын хурал дээр сургуулийн хүүхэд хамгааллын багаас нэгдсэн байдлаар тайлагнаж, улмаар анги тус бүрийн хурал дээр эцэг эх, асран хамгаалагч нэг бүрээр дараах маягтаар хэрэгжилтийг үнэлүүлнэ.

Сургууль дээр хэрэгжсэн хүүхэд хамгааллын арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх маягт

(жишээ, загвар)

Хичээлийн жил:

Сургуулийн нэр:

Анги:

Анги удирдсан багшийн нэр:

Хамрагдсан оролцогчдын тоо:

Эцэг эхийн зөвлөлийн даргын нэр:

№	Арга хэмжээний нэр	Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ	Үнэлгээний тайлбар	Дараагийн хичээлийн жилийн төлөвлөгөөнд тус арга хэмжээг дахин оруулах уу?	Дараагийн хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний санал
1.					
2.					
3.					
4.					
5.					

Арга зүйн зөвлөмж: Үнэлгээ өгөгдөж буй арга хэмжээ нь сургуулийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээ байх шаардлагатай.

Маягтын тайлбар:

- **Арга хэмжээний нэр** хэсэгт эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага, дадлыг олгох сургалт гэх мэтээр арга хэмжээний нэрийг бичнэ.

- **Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ** хэсэгт сайн, дунд, муу, үнэлж мэдэхгүй гэсэн сонголтуудаас сонгож тухайн арга хэмжээнд үнэлгээ өгнө.
- **Үнэлгээний тайлбар** хэсэгт арга хэмжээнд яагаад тухайн үнэлгээг өгсөн шалтгаанаа бичнэ. Жишээлбэл: сургалтын агуулга ерөнхий, өгөөжгүй байсан гэх мэт.
- **Дараагийн хичээлийн жилийн төлөвлөгөөнд тус арга хэмжээг дахин оруулах уу?** хэсэгт тийм, үгүй гэсэн сонголтоос сонгож хариулна.
- **Дараагийн хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний санал** хэсэгт нээлттэй байдлаар саналыг нь бичүүлж авна.

Анги тус бүрээр дээрх үнэлгээний нэгтгэлийг анги удирдсан багш хариуцаж хийж өгөх бөгөөд сургуулийн хэмжээний үнэлгээний нэгтгэлийг нийгмийн ажилтан хариуцан хийхийг зөвлөж байна. Харин сургуулийн хүүхэд хамгааллын багаас үзүүлсэн шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах болон нөхөн сэргээх үйлчилгээний шуурхай болон үр дүнтэй байдал, чанарыг тухайн үйлчилгээг авсан хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчаар холбогдох хууль, журамд нийцүүлэн тусгайлан үнэлүүлж, санал хүсэлтийг шийдвэрлэх нь зүйтэй юм. Ингэхдээ “Сургуультай хамтран Хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд боловсруулж, Боловсролын яамаар батламжилсан “Ерөнхий боловсролын сургуулийн Хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар” гарын авлагад заагдсан арга зүйг үндэслэнэ.

НҮБ-ын Хүүхдийн Сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн болон техникийн дэмжлэгтэйгээр Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хамтран гүйцэтгэсэн “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн

судалгаа-2023” судалгаагаар⁴ 4 суралцагч тутмын 3 нь сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдаагүй гэж үзсэн эерэг үр дүн гарсан ч 3 суралцагч тутмын 1 нь сургууль дээрээ дээрэлхэлтэд өртөж байсан гэжээ. Түүнчлэн эмэгтэй 5 суралцагч тутмын 1, эрэгтэй 7 суралцагч тутмын 1 нь цахим дээрэлхэлтэд өртөж байна гэсэн таагүй үр дүн гарсан. Илүү ноцтой нь 2 суралцагч тутмын 1 нь өөрийнх нь асуудал, санаа зовнилыг эцэг, эх, асран хамгаалагчид нь огт ойлгодоггүй гэсэн бол 3 суралцагч тутмын 1-ийн эцэг, эх, асран хамгаалагчид нь сүүлийн нэг сар чөлөөт цагаараа юу хийж байгааг нь огт мэдээгүй байсан гэж хариулжээ. Энэ нь сургуулийн орчинд хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөлт сайтай, далайцтай, үр дүнтэйгээр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг нотолж байгаа үр дүн юм. Тиймээс сургуулиуд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоотойгоор эдгээр арга хэмжээг төлөвлөж, үр дүнг нь хамтдаа хянаж, сайжруулах хэрэгтэй байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

2024 оноос эхлэн Ерөнхий боловсролын сургуулиуд хүүхэд хамгааллын зардлын төсөвтэй болсон бөгөөд сургууль дээр зохион байгуулах хүүхэд хамгааллын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх болон гүйцэтгэлийг үнэлж, дүгнэхэд олон нийт буюу эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог төдийлөн хангаж чадахгүй байна. Энэ нь төсвийн зарцуулалтын үр ашиг, үр дүнтэй байдал, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэдийн оролцоотой үнэлж, сайжруулах буюу нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм. Тиймээс сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд иргэд буюу эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхой болгох

4 Өсвөр насны хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн өнөөгийн байдлыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалын дагуу судлан, тогтоож, засгийн газрын бодлого, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох, суурь мэдээллийг бий болгох зорилгоор хийсэн судалгаанд ерөнхий боловсролын 51 сургуулийн 13-17 насны 3750 суралцагчийг хамруулжээ.

зорилгоор 2 үндсэн маягт, аргачлал бүхий тус гарын авлагыг боловсруулан Ерөнхий боловсролын сургуулиудад санал болгож буй юм. Энэхүү гарын авлагыг ашигласнаар

- Сургуулийн багш, ажилтнууд хүүхэд хамгааллын тухай, боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын талаар холбогдох хууль, журмын цогц ойлголттой болно.
- Сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааг төлөвлөхөд эцэг эх, асран хамгаалагчдын санал, бодлыг тусгах аргачлалд суралцана.
- Сургуулийн хэрэгжүүлсэн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын байр суурийг тусгах арга зүйтэй болох юм.

Ингэснээр сургуулийн орчинд хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын арга хэмжээний үр дүнтэй байдал сайжирч, хүүхэд эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдал хангагдах бөгөөд эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл ханамж нэмэгдээд зогсохгүй том зургаараа төсвийн хуваарилалтын үр ашиг дээшилж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, нийгмийн эгэх хариуцлага бэхжихэд чухал түлхэц болно хэмээн найдаж байна. Тиймээс сургуулиудад бидний санал болгож буй аргачлалыг наад зах нь 3 хичээлийн жил тууштай ашиглан үр дүнг нь тооцох байдлаар ажиллаж сургуулийнхаа хүүхэд хамгааллын арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үнэлгээгээ сайжруулахыг зөвлөө. Та бүхэндээ амжилт хүсье!

ХАВСРАЛТ

Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах заавар (Монгол Улсын Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/279 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаас)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Боловсролын ерөнхий хуулийн 38.1.2-т⁵ заасан хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/, ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын зардлыг /цаашид “сургуулийн хүүхэд хамгааллын зардал” гэх/ сургалтын байгууллагын түвшинд төлөвлөх, зарцуулахад энэхүү зааврыг баримтална.

1.2.Хүүхэд хамгааллын зардал нь Засгийн газрын тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүн”-д заасан хувь хэмжээгээр тодорхойлогдоно.

Хоёр. Сургуулийн хүүхэд хамгааллын зардлын төлөвлөх, зарцуулах

2.1.Сургалтын байгууллагын хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах үйл ажиллагаа нь хууль тогтоомж, батлагдсан стандарт, журамд нийцсэн, баримт нотолгоонд үндэслэсэн, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан

⁵ 38.1.2.хүүхдийн тоо, бүлэг дүүргэлт, хүчин чадлын ашиглалт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, нэмэлт хөтөлбөр, багшийн мэргэжлийн хөгжил, сургалтын цахим хэрэглээ, сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, боловсролын стандарт, багш ажилтны дундаж цалин хөлснөөс хамаарсан сургалтын үйл ажиллагааны хувьсах зардал;

сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх зарчмыг баримтална.

2.2.Тухайн жилд сургуулийн хүүхэд хамгааллын зардлын батлагдсан төсвийн 50-аас доошгүй хувийг энэ зааврын 2.5.3-д заасан үйл ажиллагаанд, 30 хүртэлх хувийг энэ зааврын 2.5.2-т заасан үйл ажиллагаанд, 20 хүртэлх хувийг 2.5.1-д заасан үйл ажиллагааны төлөвлөгөөг БЕХ-ийн 34.1, 34.2-т⁶ заасан зөвлөл батална.

2.3.Сургуулийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын багийн гишүүд нь сургуулийн хүүхэд хамгааллын зардлыг сургуулийн “Хүүхэд хамгааллын баг”-ийн жилийн ажлын төлөвлөгөөнд үндэслэн, энэ зааврын 2.2-д заасан хувь хэмжээнд нийцүүлэн, тухайн жилд шаардлагатай материал, хэрэглэгдэхүүн, үйлчилгээний жагсаалтыг гаргаж төсвийн шууд захирагчаар баталгаажуулна.

Тайлбар: Энэхүү чиглэлийн 2.3-д заасан “Хүүхэд хамгааллын баг” гэж боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан холбогдох журамд зааснаар ойлгоно.

2.4.Хүүхэд хамгааллын багийн төлөвлөгөөнд энэ зааврын 2.5-д заасан үйл ажиллагаа буюу сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй суралцагчийг илрүүлэх, эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, тэдний аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын холбогдох байгууллагад мэдээлэх, хүчирхийллийн хохирогч, холбогдогч суралцагчийг нөхөн сэргээх, чадавхжуулах, дахин хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагааг тусгана.

6 34.1.Мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургууль, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургууль болон Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулсан боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага нь удирдах зөвлөл байна.

34.2.Энэ хуулийн 34.1-д зааснаас бусад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн өөрийн удирдлага нь сургууль, цэцэрлэгийн зөвлөл байна.

2.5.Сургуулийн хүүхэд хамгааллын зардалд дараах үйл ажиллагааны зардал багтана.

2.5.1.Сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн суралцагчид үзүүлэх хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн зардал:

2.5.1.1.хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй мэдээлэл, таамгийг хүлээн авах тусгай дугаар бүхий харилцаа холбооны хэрэгсэл, утасны холбогдох төлбөр;

2.5.1.2.хүчирхийллийн хохирогч суралцагчид үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээнд шаардлагатай техник хэрэгсэл /зургийн аппарат, дуу хураагуур, энгэрийн камер гэх мэт/-ийн зардал;

2.5.1.3.хохирогч суралцагчийг хүүхэд хамгааллын болон холбогдох байгууллагын тусламж, үйлчилгээнд цаг алдалгүй хүргэх, холбон зуучлах тээвэр шатахууны зардал зэрэг багтана.

2.5.2.Хүчирхийлэлд өртсөн суралцагчийг хамгаалах, нөхөн сэргээх, суралцах үйл явцыг дэмжихэд чиглэсэн хүүхэд хамгааллын хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал:

2.5.2.1.хүчирхийллийн хохирогч, эрсдэл нөхцөлд байгаа суралцагч, суралцагчдын бүлгийг нөхөн сэргээх, дэмжих, чадавхжуулахад чиглэсэн сургуулийн нийгмийн ажлын /ажил/, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн үйлчилгээнд шаардлагатай хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, зөвлөгөө, сэтгэл заслын уулзалтын зардал;

2.5.2.2.хүчирхийллийн хохирогч, эрсдэлт нөхцөлд байгаа суралцагчид сургуулийн хүүхэд хамгааллын баг үзүүлэх боломжгүй нарийн мэргэжлийн үйлчилгээ нэмэлтээр авах тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний үйлчилгээний төлбөр;

2.5.2.3.хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлд байгаа суралцагч бүртэй ажиллах кейс менежментэд шаардлагатай харилцаа холбоо, гэрээр айлчлах тээвэр, оролцогч талуудын уулзалтад шаардлагатай зардал тус тус багтана.

2.5.3.Нийт суралцагчдыг хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлд, хорт зуршил, согтуурах, мансуурах, донтох байдал болон цахим орчин дахь болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх, өртсөн суралцагчийг дахин өртөхөөс сэргийлэх сургалт, үйл ажиллагааны зардал:

2.5.3.1.энэ зааврын 2.5.3-д заасан эрсдэлд өртөх эрсдэлтэй болон өртсөн суралцагчийг дахин өртөхөөс сэргийлэх тодорхой бүлэгт чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө, үйл ажиллагааны зардал;

2.5.3.2.хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних, илрүүлэх, мэдээлэх тухай багш, ажилтнуудад зориулсан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлын зардал;

2.5.3.3.хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмшүүлэх талаар суралцагч, эцэг эх, сургуулийн үйл ажиллагаанд хамтран оролцогч талуудад зориулсан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлын зардал;

2.5.3.4.сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээг зохион байгуулах, хянах, үнэлэх, тайлагнахад шаардлагатай үйл ажиллагааны зардал тус тус багтана.

2.6.Сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээ, үйл ажиллагаа нь ганцаарчилсан, бүлгийн зөвлөгөө, сэтгэл засал, сургалт, гэрээр айлчлах, уулзалт, сурталчилгаа, арга хэмжээ, хөтөлбөр, нөлөөллийн ажил зэрэг хэлбэртэй байна.

2.7.Сургуулийн хүүхэд хамгааллын ажлыг “Сургуулийн хүүхэд хамгааллын баг” удирдан зохион байгуулна. Хүүхэд хамгааллын баг нь энэ зааврын 2.5-д заасан үйл ажиллагааг сургуулийн удирдлага, багш ажилтан, албан хаагч, эцэг эхийн зөвлөл, мэргэшсэн байгууллага, мэргэжилтэн, суралцагч, сургагч багшийн оролцоотой хамтран зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд оролцогч талуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, сургуулийн хүүхэд хамгааллын баг хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана.

НОМ ЗҮЙ

- Монгол Улсын Их Хурал. 2024. *Хүүхэд хамгааллын тухай хууль*. Улаанбаатар.
- Монгол Улсын Засгийн газар. Дугаар 236. 2024. *Аргачлал, зардлын норматив батлах тухай тогтоол*. Улаанбаатар.
- Монгол Улсын Засгийн газар. Дугаар 53. 2024. *Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай тогтоол*. Улаанбаатар.
- Монгол Улсын Боловсролын сайд. Дугаар А/279. 2024. *Заавар шинэчлэн батлах тухай тушаал*. Улаанбаатар.
- Т.Түмэнцогтоо нар. 2017. *Нийгмийн эгэх хариуцлагын үндсэн ойлголт*. Улаанбаатар.
- Т.Түмэнцогтоо нар. 2017. *Нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслүүд*. Улаанбаатар.
- Үндэсний Аудитын Газар. 2024. *Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит*. Улаанбаатар.
- Bronfenbrenner, U. 1979. *The Ecology of Human Development*. Cambridge, MA. Harvard University Press.